



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 19 өдөр

Дугаар А/400

Арвайхээр сум

Журам батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 95/260 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам”-ын 1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын Тамгын газар, түүний хэлтэс, тасаг, албадын албан ажлын хэрэгцээнд дуудлагын автомашин ашиглах журмыг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү журмыг хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6-23 11 0772

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 8 дугаар  
сарын 19-ны өдрийн 1100 дугаар  
захирамжийн хавсралт

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ТҮҮНИЙ ХЭЛТЭС, ТАСАГ,  
АЛБАДЫН АЛБАН АЖЛЫН ХЭРЭГЦЭЭНД ДУУДЛАГЫН АВТОМАШИН  
АШИГЛАХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.3, 6.5.19-т заасны дагуу аймгийн Засаг даргын Тамгын газар, түүний хэлтэс, албад, тасгийн албан хаагчид албан үүргийн дагуу автомашин ашиглах (цаашид дуудлагын автомашин гэх) зохицуулалт, хэрэглээний хязгаарыг тогтоох, байгууллага, албан тушаалтны үүрэг, түүнд тавих хяналтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2.Албан хэрэгцээний дуудлагын автомашин ашиглахад Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль болон энэ журмыг мөрдлөг болгоно.

**Хоёр. Албан ажлын хэрэгцээнд дуудлагын автомашин ашиглах  
ажил үйлчилгээний жагсаалт**

2.1.Аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, жилийн хөгжлийн төлөвлөгөө болон байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах,

2.2.Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг газар дээр нь үзэж шалгах, зөвлөн туслах, хяналт шалгалт үнэлгээ хийх,

2.3.Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх зорилгоор нөхцөл байдалтай нь газар дээр нь очиж танилцах, санал дүгнэлт гаргах, шийдвэрлэх,

2.4.Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа ажлуудын хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих,

2.5.Дээд шатны байгууллага болон бусад байгууллагуудаас ирүүлсэн удирдамж, хөтөлбөрийн дагуу хурал, зөвлөгөөн, сургалтад оролцох, зохион байгуулах,

2.6.Тухайн төсвийн жилийн явцад шинээр батлагдсан хууль тогтоомж, Засгийн газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг даргын шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор батлагдсан удирдамж хөтөлбөрийн дагуу ажиллах,

2.7.Ээлжит цэрэг татлагыг зохион байгуулах, тайлан мэдээг хүргүүлэх, орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн дадлага, сургуулилалт явуулах.

Гурав. Албан хэрэгцээнд дуудлагын автомашиныг ашиглах  
хэрэглээний хязгаар



3.1. Дуудлагын автомашин ашиглаж байгаа албан тушаалтан суурин газарт хоногийн 40 км, сум, аймаг, хот хооронд батлагдсан зай хоорондын тарифыг хэтрүүлэхгүй тус тус ашиглана,

3.2. Дуудлагын бензин автомашины шатахуун зарцуулалт нь 100 км-т зуны улиралд 18, өвлийн улиралд 20 литр, дизель хөдөлгүүртэй автомашины шатахуун зарцуулалт нь 100 км-т зуны улиралд 16, өвлийн улиралд 18 литрээс илүүгүй байна,

3.3. Зайлшгүй тохиолдолд Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлаг нь дуудлагын автомашин ашигласан тохиолдолд үйлчилгээний төлбөрийг Улаанбаатар хот болон бусад аймагруу 1 км тутамд 1600 төгрөг, хөдөө сумдад 1 км тутамд 1650 төгрөгөөр тооцно,

3.4. Дуудлагын автомашиныг ашиглахдаа суудлын багтаамжийг бүрэн ашиглах чиглэлийг баримтална,

3.5. Дуудлагын автомашиныг ашиглах албан тушаалтан ажлын 3-аас доошгүй өдрийн өмнө мэдэгдсэн байна.

Дөрөв. Автомашины ашиглалт, хадгалалт хамгаалалт

4.1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийтлэг үйлчилгээний алба нь дуудлагын автомашинуудыг төвлөрүүлж, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих бөгөөд жолоочтой гэрээ байгуулж, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал, техникийн болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр арилгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ,

4.2. Дуудлагын автомашины техникийн болон засвар үйлчилгээг холбогдох стандартын дагуу тогтоосон хугацаанд тогтмол хийж гүйцэтгэнэ,

4.3. Дуудлагын автомашин нь Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS 4598:2020 стандартын шаардлагыг хангасан байна,

4.4. Дуудлагын автомашины жолооч нь техникийн болон замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж ажиллах үүрэгтэй,

4.5. Дуудлагын автомашиныг техникийн үзлэгт хамруулан, жолоочийн хариуцлагын албан журмын болон тээврийн хэрэгслийн даатгалд хамруулна.

Тав. Төлбөр тооцоо, шатахуун зарцуулалтад тавих хяналт

5.1. Энэ журмын 3.3-т заасны дагуу дуудлагын автомашиныг бусад байгууллагын албан хэрэгцээнд ашигласны төлбөрийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийтлэг үйлчилгээний албанд төвлөрүүлж, түүнээс шатахуун, жолоочийн томилолт, засвар үйлчилгээний зардлыг барагдуулна,

5.2. Энэ журмын 3.1, 3.2-т заасан зардлын нормативыг хэтрүүлэн хэрэглэсэн тохиолдолд тухайн албан тушаалтнаар төлүүлнэ,

5.3. Дуудлагаар үйлчлэх автомашины жолооч нь шатахуун хүссэн шаардах хуудсыг, жолоочийн тооцооны хуудсын хамт удирдлагаар хянуулсны дараа нягтлан бодогч шатахууны баримтыг олгоно,

5.4. Албан ажлын хэрэгцээнд автомашин ашигласан албан хаагч явсан километрийг хянаж "Жолоочийн тооцооны хуудас"-т гарын үсэг зурж баталгаажуулж, жолооч түүнийг Нягтлан бодогчид хүлээлгэн өгч тооцоо нийлнэ,

5.5. Энэхүү журмын 5.4-т заасан тооцоо нийлээгүй албан тушаалтан, жолоочид дараагийн шатахуун зарцуулах эрх олгохгүй.

#### Зургаа. Бусад

6.1. Дуудлагын автомашин ашиглаж байгаа албан тушаалтан нь бусад төрийн байгууллага хуулийн этгээдээс шатахууны болон бусад зардлыг давхардуулан гаргуулахыг хориглоно,

6.2. Энэ журмын 2-т заасан ажилд дуудлагын автомашин хүрэлцээгүйн улмаас хувийн автомашин ашигласан албан тушаалтанд шатахууны зардлыг батлагдсан тарифын дагуу нөхөж олгоно,

6.3. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэж, учруулсан хохирол, төлбөрийг нөхөн төлүүлнэ.